

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/783
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ухаалаг засаг төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ухаалаг засаг төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ухаалаг засаг төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Төслийн зохицуулагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Ухаалаг засаг” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Ч.Нургул Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цалин хөдөлмөрийн хөлсний тооцоолол тайлагналыг үнэн зөв хийх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Ухаалаг засаг” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Ухаалаг засаг” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 19-өөс 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мүүрь Аудит ХХК-ийн баталгаажуулах үйлчилгээний менежер П.Нарантуяа ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Ухаалаг засаг” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Мүүрь Аудит ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 21 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Ухаалаг засаг” төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсад мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйл ажиллагаанд оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгоход оршино.

“Ухаалаг засаг” төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийн оролцоог дэмжих;
- Төрийн мэдээллийн технологийн нэгдсэн тогтолцоог бий болгох;
- Төрийн өгөгдөл мэдээллийн нээлттэй орчныг бий болгох гэх мэт байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн нийгмийн даатгалын хувь хэмжээ;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос хөнгөлөх албан татварын хөнгөлөлтийн хэмжээ өөрчлөгдсөн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Ухаалаг засаг” төслийн мөрдөж байгаа Санхүүгийн удирдлагын гарын авлага нь Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн гарын авлага, холбогдох дүрэм, журамтай нийцсэн байна.

“Ухаалаг засаг” төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Инфо системс программ хангамж ашигладаг байна.

“Ухаалаг засаг” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Ухаалаг засаг” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 11,020,295.5 мянган төгрөгөөс тооцон 110,203.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдалд өөрчлөлт ороогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Ухаалаг засаг” төсөл 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 246,832.5 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, Засгийн газрын оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,397,496.4	2,397,496.4
Үндсэн хөрөнгө	-	70,703.6	70,703.6
Нийт хөрөнгө	-	2,468,200.0	2,468,200.0
Өр төлбөр	-	2,889.7	2,889.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	2,465,310.3	2,465,310.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	2,468,200.0	2,468,200.0

Төслийн шууд захирагч 2019 онд солигдсонтой хамааралтайгаар санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт эхний үлдэгдэлгүй байна.

Санхүү байдлын тайлан эхний үлдэгдэлгүй тул тайлант хугацаанд мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо өсөлттэй гарсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт зориулан 11,592,259.1 мянган төгрөгийн төсвийг төсөл, хөтөлбөрийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 11,592,259.1 мянган төгрөгийг гадаад эх үүсвэрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гадаад эх үүсвэрийн санхүүжилтийн дүн 938,823.0 мянган төгрөгөөр тасарсан нь Дэлхийн банкны санхүүжилтээс шалтгаалсан байна.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци ба Олон Улсын Сэргээн Босголтын Хөгжлийн Банк болон Монгол Улсын Засгийн Газрын хооронд байгуулсан санхүүжилтийн хэлэлцээрт заагдсанаар аливаа төлбөрийг мөнгөөр төлсөн үед зардлаар хүлээн зөвшөөрч, санхүүжилтийн нөхөн дүүргэлт хийгддэг учраас санхүүжилт төсөвлөсөн хэмжээнээс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,004,408.2 мянган төгрөг буюу 95 хувьтай байгаа нь төсөл хөтөлбөрийн зарим зардлын гэрээг Дэлхийн банкны зөвшөөрөл олгосны дагуу тайлант оны эцсээр байгуулсанаас шалтгаалсан байна.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан сургалтууд, төслийн зөвлөхийн цалин, хөлс, жилийн гүйцэтгэлийн үнэлгээг хийх болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд 2,614,639.9 мянган төгрөг, бараа худалдан авахад 8,389,768.3 мянган төгрөгийн зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,889.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,889.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

Цалингийн өглөгийг 358.2 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөгийг 2,531.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дүгээр заалттай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй тул залруулга хийлээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төслийн хугацаа дуусах тул Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөлт тухайн жилд хэрэгжиж байгаа эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Ухаалаг засаг” төсөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 15 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, хугацаатай зөвлөмж өгөөгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Ухаалаг засаг” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Ухаалаг засаг” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭИ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	2,397,496,412.97
31211	Банкинд байгаа бэлэн мөнгө (төгрөгөөр)	-	7,050,667.50
31223	Банкинд байгаа бэлэн мөнгө (гадаад валютаар)	-	2,390,445,745.47
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,397,496,412.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	70,703,634.18
39200	Биет хөрөнгө	-	68,741,168.43
39203	Авто тээврийн хэрэгсэл	-	74,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(15,800,821.92)
39205	Машин тоног төхөөрөмж/компьютер/	-	27,343,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(20,781,136.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	12,041,690.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(8,962,163.65)
39300	Биет бус хөрөнгө	-	1,962,465.75
39301	Программ хангамж	-	6,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(4,537,534.25)
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	70,703,634.18
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,468,200,047.15
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41310	Ажилчидтай холбоотой өглөг	-	358,199.77
41363	Татварын өглөг	-	2,531,535.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	2,889,735.47
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
51200	Хуримтлагдсан үр дүн	-	2,465,310,311.68
51210	Өмнөх үеийн үр дүн	-	2,715,008,766.29
51220	Тайлант үеийн үр дүн	-	(249,698,454.61)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	-	2,465,310,311.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	-	2,468,200,047.15

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,707,393,473.99
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	53,957,327.39
1220044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-	10,653,436,146.60
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	10,707,393,473.99
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЛАГЫН ДҮН (II)	-	11,023,161,492.47
2104	Хангамж, бараа материалын зардал	-	13,196,080.07
210401	Бичиг хэрэг	-	1,251,554.54
210402	Тээвэр, шатахуун	-	3,399,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	8,544,975.53
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	10,940,120,809.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,940,120,809.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,887,275.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	15,887,275.97
2133	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	53,957,327.39
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		53,957,327.39
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-	(315,768,018.48)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	66,069,563.87
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	66,069,563.87
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-	(249,698,454.61)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	13,335,835,033.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	13,335,835,033.84
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	53,957,327.39
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	-	10,653,436,146.60
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	2,628,441,559.85
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	-	11,004,408,184.74
2104	Хангамж, бараа материалын зардал	-	13,196,080.07
210401	Бичиг хэрэг	-	1,251,554.54
210402	Тээвэр, шатахуун	-	3,399,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	8,544,975.53
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	10,937,254,777.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,937,254,777.28
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	53,957,327.39
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	53,957,327.39
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	2,331,426,849.10
VII	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	66,069,563.87
14	Бусад эх үүсвэр	-	66,069,563.87
145001	Гадаад валютын хангийн зөрүүгийн олз	-	66,069,563.87
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(VI)+(VII)	-	2,397,496,412.97
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,397,496,412.97

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		-	-
Залруулсан үлдэгдэл		-	-
Тайлант үеийн үр дүн		-	-
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		2,715,008,766.29	2,715,008,766.29
Тайлант үеийн үр дүн		(249,698,454.61)	(249,698,454.61)
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	2,465,310,311.68	2,465,310,311.68

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,592,259,100.00	11,004,408,184.74	641,808,242.65	94.9
УРСГАЛ ЗАРДАЛ	11,592,259,100.00	11,004,408,184.74	641,808,242.65	94.9
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,592,259,100.00	11,004,408,184.74	641,808,242.65	94.9
Хангамж, бараа материалын зардал	116,400,000.00	13,196,080.07	103,203,919.93	11.3
Бичиг хэрэг	24,000,000.00	1,251,554.54	22,748,445.46	5.2
Тээвэр шатахуун	36,000,000.00	3,399,550.00	32,600,450.00	9.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,000,000.00	8,544,975.53	27,455,024.47	23.7
Ном хэвлэл	8,400,000.00		8,400,000.00	
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл	12,000,000.00		12,000,000.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	18,000,000.00	-	18,000,000.00	
Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00		12,000,000.00	
Тавилга	6,000,000.00		6,000,000.00	
Томилолт, зочны зардал	134,400,000.00	-	134,400,000.00	
Гадаад албан томилолт	67,200,000.00		67,200,000.00	
Дотоод албан томилолт	36,000,000.00		36,000,000.00	
Зочин төлөөлөгч хүлээн авах	31,200,000.00		31,200,000.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,323,459,100.00	10,937,254,777.28	386,204,322.72	96.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,323,459,100.00	10,937,254,777.28	386,204,322.72	96.6
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		53,957,327.39	(53,957,327.39)	
Төвлөрүүлэх шилжүүлэг		53,957,327.39	(53,957,327.39)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,592,259,100.00	13,401,904,597.71	(1,809,645,497.71)	115.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,592,259,100.00	13,401,904,597.71	(1,809,645,497.71)	115.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		53,957,327.39	(53,957,327.39)	
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	11,592,259,100.00	10,653,436,146.60	938,822,953.40	91.9
Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		2,628,441,559.85	(2,628,441,559.85)	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз		66,069,563.87	(66,069,563.87)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,397,496,412.97		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО				
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0
Үйлчлэх ажилтан				
Гэрээт ажилтан				

